

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-9

1.Монгол Улсын Их Хурлын дарга Дашзэвгийн Амарбаясгаланг өөрийнх нь хүсэлтээр чөлөөлөх саналыг хэлэлцэх	4-9
---	-----

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 10 дугаар сарын 16-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 59 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Б.Батбаатар;
Чөлөөтэй: Ж.Баярмаа, Т.Доржханд, Л.Оюун-Эрдэнэ, Г.Уянгахишиг,
Д.Энхтуяа;
Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар, Ө.Шижир.

Нэг.Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалангийн үүрэгт ажлаасаа өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтийг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт А.Амармэнд, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ танилцуулж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх тул Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг асуулт, саналгүйгээр хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр үг хэлэв.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Их Хурлын дарга Дашзэгвийн Амарбаясгалангийн өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 0
Бүгд: 23
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир “Д.Амарбаясгаланг Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 14 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 71.9 хувийн ирцтэйгээр 17 цаг 13 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 17 цаг 00 минут

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Сандаг-Очир: 40 минутад товлогдож байна. Яаралтайгаар.

Тийм учраас ажлын алба, Байнгын хорооны гишүүдийг хуралдаа ирэхийг урьж байна.

Хэлэлцэх асуудал Улсын Их Хурлын даргын асуудлыг хэлэлцэнэ.

Байнгын хорооны гишүүдийг хуралдаа ирэхийг урьж байна.

Одоогийн байдлаар Аюушийн Ариунзаяа, Жадамбын Бат-Эрдэнэ, Баярмагнайн Баярбаатар, Энхбатын Болормаа, Чинбатын Номин, Цэндийн Сандаг-Очир, Дашзэвгийн Амарбаясгалан зэрэг 7 гишүүн хүрэлцэн ирсэн байна.

21.9 хувийн ирцтэй байна. Одоо 4 гишүүн ирчихвэл ирц хүрэх гээд байна. Гишүүдээ дуудаарай. Гишүүд ер нь ордонд байх ёстой доо. Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн байна. Энхбатын Болормаа гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат, Чулуунбилигийн Лодойсамбуу, Чинбатын Номин, Эрдэнэбилигийн Одбаяр, Цэндийн Сандаг-Очир, Отгоны Саранчулуун, Бадарчийн Хэрлэн, Одонгийн Цогтгэрэл, Дашзэвгийн Амарбаясгалан гэсэн 10 гишүүн. Нямтайширын Номтойбаяр гишүүн орж ирж байна. Ингээд 14 гишүүн ирээд байна. хуралдаа.

Орж ирээгүй байгаа гишүүдийн нэрийг дуудъя.

Оюунсайханы Алтангэрэл гишүүн гадаад томилолттой, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн, Батын Батбаатар гишүүн гадаад томилолттой, Жудгийн Баярмаа гишүүн орж ирээрэй. Сандагийн Бямбацогт гишүүн хуралдаа орж ирээрэй. Амгаланбаатарын Ганбаатар гишүүн хуралдаа орж ирээрэй. Лувсаннъямын Гантөмөр гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Тогмидын Доржханд гишүүн, Сархадын Зулпхар гишүүн, Лхагвын Мөнхбаатар гишүүн, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ гишүүн, Цэвэгдоржийн Туваан гишүүн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Энх-Амгалан гишүүн ирцэд орсон уу? Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн, Доржзавдын Энхтуяа гишүүд хуралдаа ирж ороорой.

Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул ТББХ-ны 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанд Дашзэгвийн Амарбаясгалан гишүүн, Аюушийн Ариунзаяа гишүүн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Баярмагнайн Баярбаатар гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Лувсанн्याмын Гантөмөр гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Сархадын Зулпхар гишүүн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн, Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн, Чинбатын Номин гишүүн, Нямтайширын Номтойбаяр гишүүн, Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Цэндийн Сандаг-Очир, Отгоны Саранчулуун гишүүн, Цэвэгдоржийн Туваан гишүүн, Бадарчийн Хэрлэн гишүүн, Одонгийн Цогтгэрэл гишүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн гэсэн 32 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирсэн байна аа.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын дарга Дашзэгвийн Амарбаясгалан өөрийн чөлөөлөгдөх хүсэлтээ Улсын Их Хуралд 2025 оны 10 сарын 16-ны өдөр гаргасан.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаасаа өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан Амарбаясгалан даргын асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12.3-д Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх, огцруулах асуудлыг ТББХ-ны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, чөлөөлөх, огцруулах асуудлыг ил санал хураалтаар шийдвэрлэнэ.

Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх огцруулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно оо гэсэн байна аа.

Ингээд Монгол Улсын Их Хурлын дарга Дашзэгвийн Амарбаясгалан үүрэгт ажлаасаа өөрөө чөлөөлөгдөх хүсэлтээ танилцуулна аа.

Амарбаясгалан даргын микрофоныг өгье өө.

Д.Амарбаясгалан: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая.

Би өөрийн хүсэлтийг гаргасан. Хүсэлтээ сая даргын дэргэдэх зөвлөл дээр танилцуулж өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хороогоор болон өнөөдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэх тов дараалалд оруулсан байгаа юм аа. Би ингээд өргөдлөө уншиж танилцуулъя аа.

Монгол Улсын Их Хуралд чөлөөлөгдөх хүсэлт гаргах тухай

Дашзэвэгийн Амарбаясгалан Миний бие Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгийн иргэдийн итгэл дэмжлэгийг авч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон.

Улмаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасны дагуу сонгуулийн үр дүнгээр 64 ба түүнээс дээш суудал авсан МАН-аас нэр дэвшүүлснээр 2024 оны 7 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн Монгол Улсын Их Хурлын даргаар сонгогдон ажиллаж байна аа. Өнөөдрийн улс төрд үүссэн хямралын шинжтэй үйл явдлууд нь МАН-ын даргын сонгуульд надад ялагдсан нөхдийн маань ялагдлаа хүлээн зөвшөөрөөгүй үйлдлээс эхлэлтэй ч өдгөө Монгол Улсын парламентын ардчилал болон төрийн засаглалыг эрсдэлд орууллаа.

Цаашилбал ард түмний төрд итгэх итгэл дэмжлэгийг сулруулж нийгмийг талцал хуваагдалд хүргэн үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байна аа. Мөн сонгуульд өрсөлдөөд ялагдсан нөхдийн маань эрх мэдлийн төлөө тэмцэлдэх улайрал нь гүйцэтгэх засаглалын дүрэмгүй, хуульгүй дураар авирлалт болж төрийн эрх барих дээд байгууллага болон хууль хяналтын байгууллагуудад Үндсэн хуулийг зөрчин нөлөөлж байна аа.

Улмаар үндэслэлгүй гүтгэлгийг зохион байгуулалттайгаар бүхий л сувгаар түгээн миний нэр төрийг гутаан доромжилж байгаа нь туйлын харамсалтай байна.

Иймд миний бие өөрийн нэр төрөө бүрэн сэргээх, парламентын ардчилал, эрх чөлөө, засаглалаа хамгаалж шударга ёсыг тогтоохын төлөө Монгол Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас өөрийн саналаар чөлөөлөгдөх хүсэлтээ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалтад заасны дагуу гаргаж байна аа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Ц.Сандаг-Очир: Чөлөөлөгдөх хүсэлтээ танилцууллаа. Горимын санал аа?

Амарбаясгалан даргад горимын санал байна гэнэ.

Д.Амарбаясгалан: Горимын санал. Ингээд өөрөө өргөдлөө өгч байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор мэдээж Улсын Их Хурлын гишүүдэд олон асуулт дээрээс нь саналууд байгаа гэж ойлгож байна. Тэгээд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан өнөөдөр өглөө 10 цагаас хойш ирц бүрдэхгүй хэлэлцэх асуудлууд хүлээгдэж байгаа учраас чуулганы нэгдсэн хуралдаан дээр орж гишүүд маань асуулт асууж, санал хэлэхийг хүсэж байгаа юм.

Тийм учраас Байнгын хорооны хурлыг асуулт, саналгүйгээр асуудлыг шуурхай шийдвэрлэж өгөөч ээ гэсэн горимын санал гаргаж байна аа. Горимын саналыг дэмжиж өгөхийг хүсье. Мөн дээрээс нь Улсын Их Хурлын гишүүдийг бас гаргасан хүсэлтийг маань хүндэтгэж одоо асуудлыг шийдвэрлэж дэмжиж өгнө өө гэдэгт итгэж байна аа.

Ц.Сандаг-Очир: Горимын санал гаргаж байна. Хэлэлцэж байгаа асуудлыг асуулт үггүйгээр одоо хэлэлцүүлж өгөөч ээ гэсэн горимын санал гаргаж байна. Горимын саналаар санал хураалт.

Горимын санал гаргасан. Тийм учраас асуулт үггүйгээр. Горимын саналтай холбогдуулж горимын санал гаргах гэж байгаа юм уу? Горимын саналаас уу? Манай Байнгын хорооны гишүүн асуулт байж болох уу? Энхбаяр гишүүн асуултаа асууя. Горимын саналтай холбогдуулж.

Ж.Энхбаяр: Их Хурлын дарга, Улсын Их Хурлын даргын албан тушаалд чөлөөлөх хүсэлт гаргасан байна.

Энийг гишүүдийн анхааралд Монгол Улсын Ерөнхий сайдын Засгийн газрын огцрох асуудал Байнгын хороонд хэлэлцэх тэр процесс, өнөөдрийн процесс 2-ыг харьцуулж нэг тодотгож Байнгын хорооны дарга ажиллаад л мэдээлэл өгмөөр байна. Яагаад гэвэл Ерөнхий сайдыг буюу Засгийн газар огцруулах онцгой бүрэн эрх зөвхөн Их Хурлын 126 гишүүнд хадгалагдана. Байнгын хороонд биш. Байнгын хороо асуудлыг хэлэлцээд Улсын Их Хуралд сонсгодог. Улсын Их Хурал зөвхөн сонсоно. Тэгээд шийдвэрээ гишүүдийн бүрэн эрхийг хангаж, 126 гишүүн санал хураалтад орох. Огцруулах эсэхээ шийддэг. Зөвхөн онцгой ганцхан тохиолдолд Ерөнхий сайд дээр л байдаг.

Улсын Их Хурлын дарга албан тушаалаар өгсөн асуудал дээр Байнгын хороо дүгнэлт гаргадаг. Санал, дүгнэлт гаргаад түүнийг нь Улсын Их Хурал л хэлэлцдэг. Энэ маш том Үндсэн хуулийн суурь өөр зарчим байхгүй юу. Тэгэхээр энд Байнгын хороо юу гэж хэлэлцсэн юм, юу гэж дүгнэсэн гэдэг зүйлгүйгээр чуулганд оруулах нь өөрөө ахиад зөрчлөөрөө явна. Ерөнхий сайдыг сонгох асуудал дээр Байнгын хороо юу ярьсан нь Их Хуралд хамаагүй. Энэ бол Их Хурлын онцгой бүрэн эрх буюу Их Хурал Ерөнхий сайдыг шийддэг. Их Хурлын дарга дээр тийм зохицуулалт байхгүй. Байнгын хороог сонсдог. Сонсох гэж дүгнэлтийг нь хэлэлцдэг. Байнгын хороо ингээд шийджээ. Одоо Байнгын хорооны саналаар гээд явдаг.

Ерөнхий сайд дээр бол өөр. Үндсэн хуульд заасан Ерөнхий сайдыг огцруулж Засгийн газар огцруулах гэдэг Үндсэн хуульд томъёолсон саналаар санал хураадаг. Энэ ийм том суурь зөрчлийг 2 том суурь, ийм өөр зарчмын асуудал байхгүй юу даа. Яагаад гэвэл Засгийн газар гүйцэтгэлийн тогтвортой байдлыг хангахын тулд өнгөрсөн 30 жил болсон Монголын улс төрийн гашуун сургамж дээр тулгуурлаж энэ Үндсэн хуулийн өөрчлөлт дэгийн Улсын Их Хурлын дэгийн хуулиуд чинь өөрчлөгдөж явсан юм аа гишүүд ээ. Ийм нарийн ялгаа байдаг. Тэгэхээр энэ талаас Байнгын хорооны даргаас ажлын албанаас тодруулга авмаар байна. Энэ зарчмын санал.

Ц.Сандаг-Очир: Энхбаяр сайдын үгийг сонслоо. Гаргасан горимын саналтай холбогдуулж холбоогүй асуудал тавьж байна аа.

Тийм учраас Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөж байгаа Амарбаясгалан дарга өөрөө горимын санал гаргаж асуулт үггүйгээр явчихъя аа. Дараа нь одоо чуулган хүлээгдэж байна аа өнөөдөржингөө.

Хэлэлцэх асуудлууд олон байна аа. Чуулган дээрээ асуулт асуух, үг хэлэх нь нээлттэй.

Тийм учраас Байнгын хорооны хурлыг асуулт, үггүйгээр явчихъя аа гэсэн горимын санал гаргасан.

Харин горимын санал гаргаснаар нь санал хураачихъя. Тэгээд дэмжигдвэл тэр л биз, дэмжигдэхгүй бол тэр л биз.

Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан даргын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Эхлээд гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Санал хураалтдаа бэлдсэн бол горимын саналаар хуралдааныг одоохон орохгүй байна уу уу?

Санал хураалтдаа бэлдсэн байна. Амарбаясгалан даргын гаргасан горимын саналаар хуралдааныг асуулт, үггүйгээр явуулъя аа гэсэн саналаар санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

23 гишүүнээс 17 гишүүн дэмжиж 73.9 хувиар санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдлээ.

Гишүүд Монгол Улсын Их Хурлын дарга Дашзэвэгийн Амарбаясгаланг одоо санал хураалтад ахиад санал хураалтдаа бэлдээрэй.

Хуралдаан үг саналгүйгээр явна гэж сая дэмжигдсэн учраас үг саналгүйгээр явах нь ээ. Санал хураалтдаа бэлдээрэй. Идэрбат гишүүн ороогүй байна. Даваасүрэн гишүүн ороогүй байна. Пүрэвдорж гишүүн ороогүй байна. Хэрлэн гишүүн ороогүй байна. Цогтгэрэл гишүүн ороогүй байна. Бадамсүрэн гишүүн ороогүй байна. Бямбацогт гишүүн ороогүй байна. 8 гишүүн ороогүй байна санал хураалтдаа. Даваасүрэн гишүүн ороогүй байна. Орцгоосон байна.

Монгол Улсын Их Хурлын дарга Дашзэвэгийн Амарбаясгаланг өөрийнх нь хүсэлтээр чөлөөлөх саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураая.

Санал хураалт.

23 гишүүнээс 23 гишүүн дэмжиж, 100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт хийгдсэнтэй холбогдуулж Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулъя аа.

Д.Амарбаясгаланг Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, мөн зүйлийн 12.2.1 дэх заалт, 12.3 дахь хэсэг 14 дүгээр зүйлийн 14.4.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

1.Улсын Их Хурлын гишүүн Дашзэвэгийн Амарбаясгаланг Монгол Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Улсын Их Хурлын даргыг шинээр сонгох хүртэл хугацаанд Улсын Их Хурлын даргын үүргийг хэрэгжүүлж байхыг Монгол Улсын Их Хурлын дэд дарга Хүрэлбаатарын Булгантуяад даалгасугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал чөлөөлөх санал дэмжигдсэн тул тогтоолын төслийг танилцуулж дууслаа.

Тогтоол, Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганд миний бие танилцуулна аа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье ээ.

17.13 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА